

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД

## ИРГЭД ЯАЖ ОРОЛЦОХ ВЭ?



ЭРЧИМ ХҮЧЭЭ УХААЛАГ  
ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭХ



ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ХЭМНЭЛТТЭЙ ЦАХИЛГААН  
ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ,  
АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ БАГАТАЙ  
ШИНЭ ДЭВШИЛТЭТ ТЕХНИК  
ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ



14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А



976-11-320126  
976-11-319335



info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn



Эрчим хүчний үнэ цэнэ



ЭРЧИМ ХҮЧ

ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ

# ХУУЛЬ

БИДЭНД ХЭРЭГТЭЙ ЮУ?




## ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ БИДЭНД ХЭРЭГТЭЙ ЮУ?

Хуулийн гол зорилго нь эрчим хүчний хэрэглээ өндөртэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг үүрэг хүлээлгэх замаар эрчим хүчний үр ашгийг нь дээшлүүлж хэмнэлт гаргахад оршино.

“Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-ийг улс орон даяар хэрэгжүүлэх ажлыг **Эрчим хүчний зохицуулах хороо гүйцэтгэнэ.** Энэ хуулиар эрчим хүч хэрэглэгчийг 2 ангилсан.

### ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭГЧ



#### ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ

**Үүнд:** Эрчим хүчний жилийн хэрэглээ нь харьцангуй өндөр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд багтах бөгөөд тэдгээрийн цахилгаан, дулааны эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээг Засгийн газраас тогтооно. Үүрэг хүлээсэн хэрэглэгч нь өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх **эрчим хүч хэмнэлтийн менежерийг** ажиллуулна.



#### БУСАД ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

**Үүнд:** Эрчим хүчний жилийн хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон босго хэмжээнд хүрээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана.

## ТА ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭРХЭН ЗӨВ, ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭХ ВЭ?



Бидний амьдрал эрчим хүчгүйгээр төсөөлөхөд бэрх. Эрчим хүчийг бид өдөр тутмын амьдралдаа, алхам тутамдаа хэрэглэж байна.



**ЗУРАГТ  
ҮЗЭХ**



**УС БУЦАЛГАХ,  
ХООЛ ХИЙХ**



**ГАР УТАС  
ЦЭНЭГЛЭХ**



**КОМПЬЮТЕР  
АСААХ**



**ГЭРТЭЭ  
ЗУРАГТЫГ БҮРЭН  
УНТРААХГҮЙ  
УЛААН  
ГЭРЭЛТЭЙ  
БАЙЛГАХ**



**ГАР УТСАА  
ЦЭНЭГЛЭЭД  
ЗАЛГУУРЫГ НЬ  
САЛГАХГҮЙ  
ҮЛДЭЭХ**



**КОМПЬЮТЕР,  
ПРИНТЕРЭЭ  
ТЭЖЭЭЛЭЭС  
САЛГАХГҮЙ  
ЗАЛГААТАЙ  
ОРХИХ**

гэх мэт хэзээ ч хэрэглэсэн байнгын бэлэн байдаг эрчим хүчийг бид ашиглахдаа хэмнэх, үр ашигтай хэрэглэх талаар төдийлөн анхаардаггүй. Гэсэн хэрнээ цахилгаан, дулаан тасалдах үед бид бухимддаг.

Тэгвэл та цахилгаан эрчим хүчийг хэмнэх тал дээр анхаарч, гэр бүлдээ, ажлын байрандаа хэвшил болгож чадвал **энэхүү хуулийг хэрэгжүүлж байгаа** хэрэг юм.

Энэ бүгдэд эрчим хүчийг хэрэглэсээр байдаг. Та дээрх тохиолдолд унтрааж, залгуураа салгаж хэвшвэл энэхүү **хуулийг хэрэгжүүлж буй сайн иргэн** юм.

НЭГ ӨРХИЙН ХЭРЭГЛЭЖ БАЙГАА



# ЧИЙДЭНГИЙН ТООЦООЛОЛ

Чийдэнг өдөрт 8 цаг асаана.  
Жилд асаах цаг:  $8 \times 365 = 2,920$  цаг  
Цахилгааны дундаж тариф: 130 төг/кВт.ц



Айл өрх бүрийн хэрэглэж байгаа чийдэнгийн чадал, чийдэнгийн тоо харилцан адилгүй.

Сүүлийн үед 1 гэрлийн бүрхүүлд олон чийдэн хийдэг ч болсон. Тэгэхээр та гэртээ хэрэглэж байгаа чийдэнгийн төрөл, тоогоо гаргаж тооцоолол хийгээд үзээрэй.



14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А



976-11-320126  
976-11-319335



info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn



Эрчим хүчний үнэ цэнэ

## ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ

ЭНГИЙН АРГАД СУРАЛЦААРАЙ!

ГЭРЭЛТҮҮЛГИЙГ  
**ХЭРХЭН**  
ШИЙДВЭРЛЭХ  
ВЭ?



Орон сууц болгон орой үдшийн цагаар орцондоо гэрэл асаасан байдаг. Хүн явсан ч яваагүй ч мэдээж гэрэлтэй байх нь зөв.

Гэхдээ өдөрт ийнхүү гэрлийг **10 цаг** ажиллуулахад **сард 2,340 төгрөг, жилд 28,080 төгрөгийн** зардал ойролцоогоор гардаг.

Энэ бол ганцхан орцны жишээ. Улаанбаатар хотын хэмжээнд бүх байрны орцыг тооцож үзвэл энэ маш их тоо гарна. Тиймээс **орцондоо хөдөлгөөн мэдрэгчээр асч унтардаг гэрэл тавьж хэвшвэл энэхүү зардлыг багасгах боломжтой юм.**

Мөн та гэртээ ч, ажлын байрандаа ч тухайн өрөөг ашиглаагүй бол гэрлийг заавал унтрааж хэвшээрэй.

Гэрлийн бүрхүүлдээ лед чийдэн авч хийвэл энгийн улайсдаг чийдэнгээс **50 хувь** бага эрчим хүч зарцуулдаг, мөн ашиглалтын хугацаа нь 10 дахин их байдаг.

**ТА АЛЬ ГЭРЛИЙН  
ЧИЙДЭНГ СОНГОСОН БЭ?**

<p>ЭНГИЙН УЛАЙСДАГ ЧИЙДЭН</p> <p><b>22,750</b> төгрөг</p> <p><b>1 жил</b></p>	<p>СҮҮН ЧИЙДЭН</p> <p><b>3,380</b> төгрөг</p> <p><b>1 жил</b></p>	<p>ЛЕД ЧИЙДЭН</p> <p><b>1,950</b> төгрөг</p> <p><b>1 жил</b></p>
<p><b>175</b> кВт.ц</p>	<p><b>26</b> кВт.ц</p>	<p><b>15</b> кВт.ц</p>
<p><b>60</b> Вт</p>	<p><b>9</b> Вт</p>	<p><b>5</b> Вт</p>





Цахилгаан эрчим хүчийг  
тасралтгүй үйлдвэрлэж,  
дамжуулан түгээж,  
хэрэглэгчдийг ямар ч үед  
цахилгаан хэрэглэхэд бэлэн  
байлгадаг учраас зардалд  
үндэслэсэн суурь  
хураамжийг 2000 төгрөгөөр  
тооцож хэрэглэгчдээс  
авдаг.



14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А



976-11-320126  
976-11-319335



info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn



Эрчим хүчний үнэ цэнэ



# ТА

**ХЭДЭН ТӨГРӨГ<sup>НИЙ</sup>  
ЭРЧИМ ХҮЧ**

**ХЭРЭГЛЭДЭГ ВЭ?**

ТА ХЭДЭН  
ТӨГРӨГНИЙ  
ЭРЧИМ ХҮЧ  
ХЭРЭГЛЭДЭГ ВЭ?



БУЮУ

100-145 ₮  
ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?

Бидний хэрэглэсэн цахилгааны төлбөр кВт.цагаар бодогддог.

Айл өрхийн 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний үнэ нь хэрэглээний түвшин, хоногийн цагийн ялгавартай хэрэглээ зэргээс хамаарч дунджаар **100-145** төгрөг байдаг.

Сард **250 кВт.ц** цахилгааны хэрэглээтэй өрх хоногт **дунджаар 8.3 кВт.ц** хэрэглэнэ. Үүнийг **дундаж тариф 130 төгрөгөөр** тооцвол **хоногт 1079 төгрөг** байна. Тэгэхээр танай гэр бүл хоногт нэг талхнаас хямд өртгөөр эрчим хүч хэрэглэж байгаа юм.

Орон сууцны нэг өрхийн цахилгааны сарын дундаж хэрэглээ **250 кВт.ц** орчим байдаг гэж бодоход **25,000 – 36,250 төгрөгийг** эрчим хүчний төлбөрт төлдөг.



ХӨРГӨГЧӨӨ  
**10** ЦАГ  
АЖИЛЛУУЛЖ БОЛНО.



УГААЛГЫН МАШИНААР  
**2-3** ЦАГ  
ХУВЦАС УГААНА.



**10** УДАА  
УС БУЦАЛГАЖ БОЛНО.



**2** ӨДӨР  
НӨУТБУУК АШИГЛАНА.



**15** ЦАМЦ  
ИНДҮҮДНЭ.



**5-9** ЦАГ  
ЗУРАГТ ҮЗНЭ.



# ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ НАРТ

ДАРААХ ЗӨВЛӨГӨӨГ ХҮРГЭЖ БАЙНА.

✓  
Эрчим хүчний хэмнэлттэй өндөр үр ашиг, бүтээмжтэй цахилгаан хэрэгслүүд тухайлбал индукцийн цахилгаан зуух, ЛЕД гэрэлтүүлэг ашиглах замаар эрчим хүчний төлбөрөө 15-20 хүртэл хувиар багасгаарай.

✓  
Хэрэв хоёр тарифт тоолууртай бол 21 цагаас эхлэн зарим цахилгаан хэрэгслээ ашиглах замаар эрчим хүчээ хэмнээрэй.



14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А



976-11-320126  
976-11-319335



info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn



Эрчим хүчний үнэ цэнэ




ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ХЭМНЭЛТТЭЙ  
ДЭВШИЛТЭТ  
ТЕХНОЛОГИ БҮХИЙ  
ЦАХИЛГААН БАРААГ  
ХЭРХЭН СОНГОХ ВЭ?



Сүүлийн үеийн цахилгаан хэрэгслүүдэд эрчим хүч хэмнэлтийн тэмдэглэгээг заахаас гадна жилд хэрэглэх цахилгааны хэмжээг зааж өгсөн байдаг.


### ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР

#### Угаалгын машин



A+++ тэмдэглэгээтэй бүтээгдэхүүн нь цахилгаан зарцуулалт хамгийн бага, эрчим хүчний үр ашигтай бөгөөд улаан өнгө рүү ойртох тусам цахилгаан зарцуулалт ихэснэ.

Эндээс зөвхөн хөргөгчний төлбөрийг **3 дахин бууруулах боломж** байгааг харж болно.




Дээрх зурагт харуулснаар A+++ тэмдэглэгээтэй хөргөгч жилд 191 кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэхээр байгаа нь A ангиллын 590 кВт.ц хэрэглээтэй харьцуулахад 3 дахин бага цахилгаан эрчим хүч хэрэглэхээр байна.



156 kWh/annum

189 kWh/annum



Энэ хоёр угаалгын машины алийг сонгох нь хялбар боллоо. Жилд 156 кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэдэг машин сонгосноор та сард 156/12=13кВт.ц буюу угаалгын машинаа бүтэн сар ашиглаад 1690Т төлөх юм.





14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А

976-11-320126  
976-11-319335

info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn

Эрчим хүчний үнэ цэнэ



ЭРЧИМ ХҮЧ  
**ХЭМНЭХ**  
**АРГУУД**

## УЛААН НОГООН ГЭРЭЛ



► Хэрэглээгүй зурагт, DVD тоглуулагч, хөгжим, гар утасны цэнэглэгч, хэт богино долгионы зуух зэргийн залгуурыг салгаж хэвших.

► Ажлаа хийж дуусаад компьютероо унтраасан бол мөн л залгууруудыг салгаж байх.

► Эрчим хүчний зарцуулалтаараа хамгийн хэмнэлттэй "A" ангиллын ахуйн техник хэрэгслийг ашиглах.



## УГААЛГЫН МАШИН

► Хувцас угаахдаа 30°C-ийн температуртай угаахад 40% цахилгааны хэрэглээг багасгана.

► A, A+, A++ тэмдэглэгээ бүхий эрчим хүчний хэмнэлттэй угаалгын машинууд нь угаах хувцасны жинг автоматаар тодорхойлж, усны хэмжээг тохируулдаг тул усыг халаахад зарцуулах цахилгаан эрчим хүч 40 хувь хүртэл хэмнэгдэнэ.

## ЦАХИЛГААН ЗУУХ



► Цахилгаан зуухны ширэмний диаметртай тэнцүү буюу түүнээс бага зэрэг илүү хэмжээний ёроолтой сав ашиглаж байх.

► Савныхаа тагийг тавьж байх.

► Хоол ундыг буцалсны дараа цахилгаан зуухны температурын шатлалыг бууруулах эсвэл хоол бүрэн болохоос өмнө цахилгаан зуухыг тасалж үлдэгдэл дулааныг ашиглах.

## ХӨРГӨГЧ



► Хөргөгчийг хийн болон цахилгаан зуух, халаагуур /радиатор/-ын ойролцоо байрлуулахгүй байх.

► Хөргөгчийн ар тал, өрөөний хана хоорондох зай хол байвал эрчим хүчийг бага зарцуулна.

► Халуун хоол, хүнсний бүтээгдэхүүнийг өрөөний температур хүртэл хөргөсний дараа хөргөгчид хийж байх.

## УС БУЦАЛГАГЧ

► Ус буцалгагчид хаг хусам үүссэн бол цэвэрлэж байх.

► Зөвхөн хэрэгтэй хэмжээгээр усаа тохируулж буцалгах.



## ТООС СОРОГЧ

► Тоос сорогчийн тоос цуглуулагч, шүүлтүүрийг цаг хугацаанд нь цэвэрлэх.



## ИНДҮҮ

► Хэт хуурай, хэт чийглэг хувцсыг удаан индүүдэх шаардлагатай болдог тул цахилгаан эрчим хүч их хэрэглэнэ. Тиймээс хувцсаа индүүдэхэд тохируулан хатаах.

► Хувцасны төрөлдөө тохируулж температурыг бууруулах дарааллаар индүүдэх.





# ТА ЯАГААД ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ ВЭ?



14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А



976-11-320126  
976-11-319335



info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn



Эрчим хүчний үнэ цэнэ




## ТА ЯАГААД ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ ВЭ?

Эрчим хүчний жилийн хэрэглээ тань Засгийн газраас тогтоосон босго хэмжээнээс давсан бол та **ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ БОЛНО.**

**1**  
ЖИЛД



**УУЛ УУРХАЙН КОМПАНИ**  
5 сая кВт.цаг  
5000 Гкал



**ҮЙЛДВЭР**  
3 сая кВт.цаг  
5000 Гкал




**ҮЙЛЧИЛГЭЭ**  
2 сая кВт.цаг  
5000 Гкал



**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА**  
2 сая кВт.цаг  
5000 Гкал

Өөрөөр хэлбэл үүрэг хүлээсэн хэрэглэгч гэдэг нь 1 жилд дээрх хэмжээнээс илүү хэрэглээтэй хэрэглэгч, аж ахуйн нэгж, байгууллагууд юм. Уг хэрэглээг хэмнэснээр байгууллагын тань зардал сараас сард, жилээс жилд нэмэгдэх бус өдөр өдрөөр хэмнэгдэх боломжтой юм.



## ХЭРХЭН ХЭМНЭХ ВЭ?

### Алхам 1

Тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгслийн ажиллагааг сайжруулах.

### Алхам 2

Шинэ дэвшилтэт техник, технологи хэрэглэх.

### Алхам 3

Ажилтан, албан хаагчдын эрчим хүчний хэрэглээний боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх.

## ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ ТАНЫ ҮҮРЭГ

- ✓ Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх;
- ✓ Эрчим хүч хэмнэлтийн менежер томилж, сургалтад хамруулах;
- ✓ Эрчим хүчний хэрэглээнд эрчим хүчний аудит хийлгэх;

- ✓ Эрчим хүч хэмнэх хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг гаргаж, үр дүнг ЭХЗХ-нд жил бүр тайлагнах;
- ✓ Эрчим хүчний хэрэглээ, энергийн урсгалыг /баланс/ тодорхойлох зорилгоор хэмжүүржүүлэх;




## ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ ТАНЫ ЭРХ


- ✓ Эрчим хүчний аудитын байгууллагыг сонгож эрчим хүчний хэрэглээндээ аудит хийлгэх;
- ✓ Эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлсний төлөө урамшуулал эдлэх;
- ✓ Эрчим хүчний аудитын зөвлөмжийг сонгон хэрэглэх;



Компьютер, принтер, хувилагч машин зэрэг цахилгаан хэрэгсэл тэжээлийн залгуурт залгаатай байх үед ажиллагаанд байх үеийн хэрэглээний 50 хувьтай тэнцэх хэмжээний эрчим хүч хэрэглэдэг.



Үүнээс сэргийлэхийн тулд өөр дээрээ унтраалгатай олон залгуур ашиглах, ашиглаагүй цахилгаан хэрэгслээ тэжээлээс салгаж хэвших нь чухал юм.



## ЭРЧИМ ХҮЧНИЙ “ШИМЭГЧ ХОРХОЙН” ТАЛААР ТА МЭДЭХ ҮҮ?



14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А



976-11-320126  
976-11-319335




info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn



Эрчим хүчний үнэ цэнэ






**ТА ГАР УТСАА ЦЭНЭГЛЭЭД,  
ЦЭНЭГЛЭГЧЭЭ ЗАЛГААТАЙ  
ХЭВЭЭР НЬ ҮЛДЭЭДЭГ ҮҮ?**

Харин энэ тоог нийслэлийн хэмжээнд авч үзвэл: Улаанбаатар хотод ойролцоогоор 380,000 өрх байдаг бөгөөд айл бүр гэртээ дор хаяж 1 гар утасны цэнэглэгч сул залгаатай орхисон бол жилд 213,408,000 төгрөгийн эрчим хүчийг дэмий алдсан байна.


Суурин компьютерийг 1 цаг ашиглахад 220 Вт цахилгаан эрчим хүч зарцуулдаг. Цайны нэг цагийн хугацаанд дунджаар 25 төгрөг, сард 740 төгрөг, жилд 8,900 төгрөгийн зардал бий болдог.

Үлдээдэг бол та цагт 0.065 төгрөг дэмий зарцуулсан байна. Энэ нь бага тоо мэт харагдаж байгаа боловч өдөржин залгаатай үлдээвэл 1.56 төгрөг, сард 46.8 төгрөг, жилд 561.6 төгрөг хий рэгдүүлсэн байна.

**УЛААНБААТАР ХОТ  
380,000 ӨРХ АЙЛ  
213,408,000₮**



**ТА ЦАЙНЫ ЦАГААРАА  
КОМПЬЮТЕР  
АСААЛТТАЙ ОРХИСНООР!!!**



Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 72,000-аад аж ахуйн нэгж, байгууллага байдаг. Байгууллага бүр дор хаяж 10 компьютертэй гэж тооцвол улсын хэмжээнд жилд 6,408,000,000 төгрөгийг үр ашиггүй зарцуулдаг байна.

Энэ тоог нэг орон сууцны 95 айлаар тооцвол жилд танай байр 53,352 төгрөгийн эрчим хүчийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь зөвхөн 1 цэнэглэгч гэдгийг анхаараарай! Танайх 2-оос 3 цэнэглэгчтэй бол илүү их эрчим хүчийг үр ашиггүй зарцуулж, илүү их төгрөгийг үрэгдүүлэх юм.



**Settings - Control panel - Power options -  
Turn off the display - 3 minutes**

тохиргоог хийснээр шаардлагагүй үед дэлгэцийг бүрэн унтрааж, компьютерийн эрчим хүч зарцуулалтыг 40 хүртэл хувь бууруулах боломжтой.

**1 ОРОН СУУЦ  
95 АЙЛ  
53,352₮**



**ТА АЖЛЫН ӨДРҮҮДЭД  
ЦАЙНДАА ГАРАХДАА  
КОМПЬЮТЕРОО  
АСААЛТТАЙ ХЭВЭЭР  
НЬ ҮЛДЭЭДЭГ ҮҮ?**



**УЛААНБААТАР ХОТ  
72,000 АЖ АХУЙ НЭГЖ  
6,408,000,000₮**



ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭМНЭЖ  
**ЭХ ДЭЛХИЙГЭЭ**  
ХАЙРЛААРАЙ



14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А



976-11-320126  
976-11-319335



info@erc.mn  
www.erc.gov.mn  
<http://ecc.erc.gov.mn>



Эрчим хүчний үнэ цэнэ




## ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ БАЙДАГ ВЭ?

Эрчим хүч нь үнэгүй зүйл биш. Та хэрэглэсэн цахилгаан, дулааны эрчим хүчиндээ сар бүр төлбөр төлдөг. Эрчим хүчээ зөв, хэмнэлттэй хэрэглэхгүй бол мөнгөө алдаж, хүрээлэн буй орчноо бохирдуулж байна.



Иймээс эрчим хүчээ хэмнэж өөрийн санхүүгээ болон эх дэлхийгээ хайрлан хамгаалаарай.



## ЯМАР ХЭРЭГСЭЛ ХАМГИЙН ИХ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ АШИГЛАДАГ ВЭ?



Өвлийн улиралд таны байшинг халаах маш их эрчим хүч хэрэгтэй. Халаагуур /радиатор/-ын градусыг бага зэрэг бууруулснаар томоохон хэмнэлт хийж чадна.



Зуны улиралд агааржуулагчийн оронд сэнс ашигласнаар их хэмжээний цахилгааныг хэмнэж чадна.



Усанд орохдоо ванныг биш, шүршүүрийг сонгож байгаарай. 5 минут шүршүүрт ороход ванны талтай тэнцэх хэмжээний ус ордог. Энэ нь ус халаах эрчим хүчийг хэмнэж байгаа юм. Мөн шүдээ угаах байхдаа усаа тусгай саванд тосч аваад, крантны усаа хааж занших хэрэгтэй.



Танай гэрийн цахилгаан хэрэгслүүдээс хөргөгч хамгийн их эрчим хүч ашигладаг.



Телевизор, компьютер, DVD тоглуулагч, богино долгионы зуухыг тэжээлээс салгахгүй бол эрчим хүч ашигласаар л байдаг. Телевизороо улаан гэрэлтэй орхиход таны үзэж байсан сүүлийн суваг хадгалагдаж, мөн цахилгааныг хэрэглэж, дулаан ялгаруулж байдаг.



Цахилгаан зуухны ширэмний диаметртэй тэнцүү буюу түүнээс бага зэрэг илүү хэмжээний жигд ёроолтой сав ашиглаж байх. Цахилгаан зуухны шугам гэмтэлтэй, савны ёроол нь жигд биш, савны ёроолын диаметр нь ширэмнийхээс бага бол цахилгаан эрчим хүчийг 40-60%-иар илүү зарцуулдаг.



Хоол ундыг буцалсны дараа цахилгаан зуухны температурын шатлалыг бууруулах, хоол бүрэн болохоос өмнө цахилгаан зуухыг тасалж үлдэгдэл дулааныг ашиглах, савныхаа тагийг тавих зэргээр хоол хийхэд зарцуулах эрчим хүчийг 15-40 % хэмнэж болно.



Бусад эрчим хүч их ашигладаг хэрэгсэлд ус халаагч, хувцас хатаагч, аяга таваг угаагч, богино долгионы зуух орно.






ЭРЧИМ ХҮЧ  
ХЭМНЭХ НЬ ЯМАР  
**АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?**



 14201, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2А

 976-11-320126  
976-11-319335

 info@erc.mn  
www.erc.gov.mn  
http://ecc.erc.gov.mn

 Эрчим хүчний үнэ цэнэ



## АЙЛ ӨРХҮҮДЭД

- Сар бүрийн цахилгаан, дулааны төлбөрөө бууруулж, мөнгөө хэмнэнэ.
- Эрчим хүчний чанар хүртээмж сайжирна.
- Хэмнэсэн зардлаа бусад зүйлдээ зарцуулах, эсвэл хуримтлал үүсгэх боломжтой болно.
- Эрчим хүч хэмнэснээр ирээдүй хойч үедээ үнэтэй хөрөнгө оруулалт хийнэ.
- Байгаль орчны бохирдлыг багасгахад хувь нэмрээ оруулж өөрийн болон үр хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаална.




## АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД

- Эрчим хүчний зардал буурна.
- Ажлын бүтээмж дээшилж, өрсөлдөх чадвар сайжирна.
- Байгалийн хязгаарлагдмал нөөцийг хэмнэнэ.
- Хүлэмжийн хийг бууруулж, экологийн тэнцвэрт байдлыг хангана.

## УЛСЫН ХЭМЖЭЭНД

- Эрчим хүчний импортыг бууруулж, энэ хэрээр гадагшаа урсах мөнгийг хэмнэнэ.
- Хэмнэсэн зардлыг бусад нийгмийн арга хэмжээнд ашиглах боломжтой болно.
- Хязгаарлагдмал нөөц болох нүүрсийг хэмнэнэ.
- Байгаль орчны бохирдолтыг бууруулж, агаарын чанарыг сайжруулна.



## ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНД

- Нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулна.
- Тогтвортой хүрээлэн буй орчныг хадгална.
- Дэлхийн дулаарал озоны давхарга цоорох аюулаас сэргийлнэ.



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨРӨӨ БАГАСГАХ ХАМГИЙН САЙН АРГУУД

- Хөргөгч, хөлдөөгчийн байршлыг өөрчлөх. Хөргөгчийг 30-50°C хэмийн бүгчим халуун өрөөнд байлгах нь энгийн үеэс хоёр дахин их эрчим хүч зарцуулдаг. Мөн плитка, ус буцалгагчийн ойр тавих нь илүү их эрчим хүч зарцуулагдахад хүргэдэг.
- Хоёр тарифт тоолууртай бол индүү, тоос сорогч, угаалгын машин зэргийг 21.00-06.00 цагийн хооронд ажиллуулах замаар өдрийн цагаар зарцуулдаг цахилгааны төлбөрөө 2 дахин багасгах боломжтой.
- Төвлөрсөн халаалтын системд холбогдсон орон сууцны айл өрхүүд эрчим хүч хэмнэхийн тулд тохируулгатай халаагуур /радиатор/-ыг сонгох.
- Төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй айл өрхүүд гэр, сууцныхаа хана, хаалга, цонх, дээвэр зэргийг дулаалах.
- Ашиглаагүй гэрэл, залгуурууд болон улаан гэрлийг тогтмол унтрааж хэвших.



Ямар нэгэн зардал гаргахгүйгээр эрчим хүчний зардлаа бууруулах боломжоо бид өөрсдөө л бүрдүүлж чадна.

Айл өрхийн гишүүн бүрт эрчим хүчийг хэрхэн зүй зохистой хэрэглэх талаар байнга сануулж хэвшүүлэх.

Аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтнууддаа эрчим хүч хэмнэх дадал хэвшил суулгах. Ингэхийн тулд уриалга гаргах, сургалт явуулах.